



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 06 сарын 20 өдөр

Дугаар A/128

Улаанбаатар хот

ШАЛГУУР БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гаалийн тухай хуулийн 185 дугаар зүйлийн 185.2 дахь хэсэг, 194 дүгээр зүйлийн 194.2 дахь хэсэг, 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.16 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Тээвэрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох шалгуур"-ыг Нэгдүгээр, "Бүрдүүлсэн бичиг баримтын жагсаалт"-ыг Хоёрдугаар, "Автотээврийн хэрэгслийн жагсаалт"-ыг Гуравдугаар, "ГИТ" таних тэмдгийн загвар"-ыг Дөрөвдүгээр хавсралт ёсоор тус тус баталсугай.

3. Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн "ГИТ" таних тэмдгийг батлагдсан загварын дагуу хэвлүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2009 оны "Тээвэрлэгч байгууллагад гаалийн итгэмжлэл олгох шалгуур батлах тухай" 224, 2014 оны "Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" A/102 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.


2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн хяналт, шалгалтын газар /П.Баттөр/-т даалгасугай.

ДАРГА



Б.АСРАЛТ

Гаалийн ерөнхий газрын даргын
2019 оны Д/128 дугаар тушаалын
Нэгдүгээр хавсралт



ТЭЭВЭРЛЭГЧ БАЙГУУЛЛАГАД ГААЛИЙН ИТГЭМЖЛЭЛ ОЛГОХ ШАЛГУУР

Нэг. Үндэслэл

1.1. Гаалийн хяналтад байгаа улс хооронд болон дотоодод дамжуулан өнгөрүүлэх барааг гаалийн байгууллагын итгэмжлэгдсэн тээвэрлэгч тээвэрлэнэ.

1.2. Гаалийн байгууллагын тогтоосон шалгуурыг хангаж, гаалийн хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхэд гаалийн байгууллагатай хамтран ажиллах тээвэрлэгч байгуулагад гаалийн итгэмжлэл олгоно.

Хоёр. Тээвэрлэгчид итгэмжлэл олгох шалгуур

2.1. Тээвэрлэлтийн 2-оос доошгүй жилийн туршлагатай, дараах шалгуурыг хангасан аж ахуйн нэгж, байгууллагад итгэмжлэл олгоно. Үүнд:

2.1.1. автозамаар тээвэрлэлт гүйцэтгэх тохиолдолд автотээврийн хэрэгсэл нь техникийн стандартын шаардлага хангасан, Монгол улсын бүртгэлд бүртгэгдэж улсын дугаар авсан, тээвэрлэгчийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй байх;

2.1.2. Монгол Улсын MNS 5346:2017 стандарт хангасан, ачаа тээвэрлэлтийн стандартыг мөрддөг талаар эрх бүхий байгууллагын дүгнэлт гаргуулсан байх;

2.1.3. тээврийн хэрэгсэл нь гаалийн байгууллагын битүүмжлэл, тэмдэглэгээ тавих боломжтой байх;

2.1.4. тээвэрлэлтийн онцгой нөхцөл шаардагдах барааг тээвэрлэх тохиолдолд тусгай зориулалтын тээврийн хэрэгсэлтэй байх;

2.1.5. гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгслийг тээвэрлэх явцад эрсдэл үүссэн тохиолдолд гаалийн болон бусад татвар хураамжийг төлж барагдуулах санхүүгийн чадавхитай болохыг сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлангаар нотолж, албан бичгээр батагаажуулсан байх;

2.1.6. тээвэрлэгч байгууллага нь сүүлийн хоёр жилийн байдлаар гаалийн байгууллагын зөрчлийн санд бүртгэгдээгүй байх;

2.1.7. гаалийн байгууллагаас автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянах боломжийг бүрдүүлэх зорилгоор тээвэрлэгч байгууллага нь тээврийн хэрэгсэл бүрт тээврийн хэрэгслийн байршлыг тогтоох систем /GPS/, цахим ломбо зэргийг байрлуулах;

2.1.8. барааг тээвэрлэх явцад бараанд үүсэх эрсдэлийг бууруулах зорилгоор ачаа тээвэрлэлтийн хариуцлагын даатгалд хамрагдсан байх.

2.1.9. Тээвэрлэгч байгууллага нь жолооч бүртэй хамтран ажиллах тухай гэрээ байгуулах.

2.2. Гаалийн итгэмжлэл авахыг хүссэн аж ахуйн нэгж, байгууллага дараах бичиг баримтыг бүрдүүлж, энэ тушаалын Хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Бүрдүүлсэн бичиг баримтын жагсаалт"-ыг бөглөж, гаалийн удирдах төв байгууллагад ирүүлнэ. Үүнд:

2.2.1. тээвэрлэлт гүйцэтгэх чиглэл, тээвэрлэх барааны нэр төрлийг тусгасан итгэмжлэл хүссэн өргөдөл;

2.2.2. тээвэрлэлтийн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар тусгасан тээвэрлэгч байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ;

2.2.3. гаалийн итгэмжлэл олгоход 2.1-д заасан шалгуурыг хангаж байгааг нотолсон баримт бичиг;

2.2.4. ачаа тээвэрлэх талаар өөр аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээ;

2.2.5. тээврийн хэрэгслийг 4 талаас (эгц урд, ард болон хажуу 2 талаас) нь авсан өнгөт зургийн эх хувь болон файл;

2.2.6. энэ тушаалын Гуравдугаар хавсралтаар батлагдсан хүснэгтийн дагуу автотээврийн хэрэгслийн жагсаалтыг Word, Excel хүснэгтээр гаргасан файл;

2.2.7. энэ шалгуурын 2.1.1, 2.1.3, 2.1.4-т заасан шалгуурыг хангаж байгаа эсэх талаар харьяалах гаалийн байгууллагын тодорхойлолт;

2.2.8. тээвэрлэгч байгууллагын танилцуулга;

2.2.9. автотээврийн үндэсний төвтэй байгуулсан "Улс хооронд ачаа тээвэрлэлт гүйцэтгэх гэрээ"-ний хуулбар, Монгол Улс, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Автотээврийн хэлэлцээрийн дагуу олгодог Зорчих зөвшөөрлийн бичиг /С зөвшөөрөл/-ийн хуулбар;

2.2.10. татварын өр авлагагүй болохыг нотлох татварын байгууллагын тодорхойлолт.

2.3. Тээвэрлэгч байгууллагад итгэмжлэл олгох, хүчингүй болгох асуудлыг гаалийн удирдах төв байгууллагын Мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, шийдвэрлүүлнэ.

2.4. Гаалийн итгэмжлэлийн хугацаа 3 жил хүртэл байна.

2.5. Автозамаар тээвэр хийхээр гаалийн итгэмжлэл авсан тээвэрлэгчийн тээврийн хэрэгсэл бүрт дараах шаардлага хангасан "Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч"-ийн товчлол "ГИТ" таних тэмдэг байрлуулна;

2.5.1. энэ шалгуурын Дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан таних тэмдэг нь тэгш өнцөгт хэлбэртэй, 14 x 7 см харьцаатай, цэнхэр өнгийн дэвсгэр дээр хөх өнгөөр "ГИТ" гэж бичсэн байх бөгөөд зүүн дээд өнцөгт Монгол Улсын гаалийн байгууллагын бэлгэ тэмдэг байх;

2.5.2. таних тэмдгийн ар талд: Тээвэрлэгч байгууллагын нэр, тээврийн хэрэгслийн марк, улсын бүртгэлийн дугаар, олгосон болон дуусах огноо бичигдсэн байх.

2.6. Гаалийн итгэмжлэгдсэн тээвэрлэгч гаалийн хяналтад тээвэрлэсэн бараа, илгээсэн болон хүргэсэн гаалийн хяналтын бүсийн код, ачааны манифестын дугаар, тээврийн хэрэгслийн дугаар зэрэг мэдээлэл агуулсан бүртгэлийг цахимаар эсхүл цаасаар хөтөлж, харьяалах гаалийн газарт улирал бүр хүргүүлнэ.

2.7.Гаалийн байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч тээвэрлэлтийн чиглэл, тээвэрлэх барааны нэр төрөл нэмэх, өөрчлөх тохиолдолд 2.1.3, 2.1.4, 2.1.5, 2.1.6, 2.1.7-д заасан шалгуурыг хангаж, 2.2.1, 2.2.4, 2.2.7, 2.2.9-т заасан бичиг баримтыг бүрдүүлж, гаалийн удирдах төв байгууллагад хүсэлт гаргана.

2.8.Хүсэлт, бичиг баримтыг гаалийн удирдах төв байгууллагын асуудал хариуцсан нэгж хянаж, шаардлага хангасан тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын дарга тушаал гаргаж шийдвэрлэнэ.

2.9.Гаалийн байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч тээврийн хэрэгсэл нэмэх тохиолдолд 2.1.1, 2.1.2, 2.1.3, 2.1.7-д заасан шалгуурыг хангаж, 2.2.1, 2.2.5, 2.2.6, 2.2.9-т заасан бичиг баримтын бүрдүүлж, гаалийн удирдах төв байгууллагад хүсэлт гаргана.

2.10.Хүсэлт, бичиг баримтыг гаалийн удирдах төв байгууллагын асуудал хариуцсан нэгж хянаж, шаардлага хангасан тохиолдолд нэгжийн даргын зөвшөөрлийг үндэслэн асуудал хариуцсан гаалийн улсын байцаагч CAIS системийн "карго" програмын "тээвэр" цэсний тээврийн хэрэгслийн санд бүртгэнэ.

2.11.Гаалийн байгууллагаас итгэмжлэл авсан тээвэрлэгч итгэмжлэлийг бусдад шилжүүлэх, худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

2.12.Гаалийн газар, хороо тээвэрлэгч байгууллагатай 1 жилийн хугацаатай гэрээ байгуулан, тээвэрлэлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана. Гэрээний хугацаа дууссан тохиолдолд сунгаж болно.

Гурав.Гаалийн итгэмжлэлийн хугацаа сунгах,
хүчингүй болгох

3.1.Итгэмжлэгдсэн тээвэрлэгч нь итгэмжлэл хүчинтэй байх хугацаанд холбогдох хууль тогтоомж зөрчөөгүй, гаалийн байгууллагаас тогтоосон шалгуурыг хангасан бол итгэмжлэлийн хугацаа сунгах тухай хүсэлтийг хугацаа дуусахаас 30 хоногийн өмнө албан бичгээр гаалийн удирдах төв байгууллагын асуудал хариуцсан нэгжид гаргана.

3.2.Хугацаа сунгах хүсэлт гаргахдаа энэ шалгуурын 2.1-д заасан шалгуурыг хангаж, 2.2.1, 2.2.3, 2.2.6, 2.2.7, 2.2.9-т заасан бичиг баримтын бүрдүүлж өгнө.

3.3.Итгэмжлэгдсэн тээвэрлэгчийн үйл ажиллагаа, хууль сахилтын түвшинг шалгаж, энэ шалгуурын 3.4.2, 3.4.3, 3.4.4, 3.4.5-т заасан нөхцөл илрээгүй тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар хугацааг сунгана.

3.4.Итгэмжлэлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно.

3.4.1.тээвэрлэгч итгэмжлэлийг хүчингүй болгох хүсэлт гаргасан;

3.4.2.тээвэрлэгчийн итгэмжлэлийн хугацаа дууссан, энэ шалгуурын 3.1-д заасан хугацаанд сунгуулах хүсэлт гаргаагүй;

3.4.3.тээвэрлэгч байгууллага нь гаалийн болон холбогдох хууль тогтоомжийн зөрчлийг 2 ба түүнээс дээш гаргасан;

3.4.4.энэ журмын 2.1-т заасан шалгуурыг хангахгүй болсон;

3.4.5.хуулийн этгээдийг үүсгэн байгуулагч, компанийн 10 хувь ба түүнээс дээш хувийн хувьцаа эзэмшигч, санхүүгийн асуудал хариуцсан нэгжийн


дарга, хуулийн зөвлөх нь сүүлийн хоёр жилд гэмт хэрэг үйлдэж, шүүхээр ял шийтгүүлсэн.

3.5.Тээвэрлэгч итгэмжлэлийг хүчингүй болгох хүсэлт гаргасан тохиолдолд гаалийн удирдах төв байгууллагын даргын тушаалаар хүчингүй болгоно.

3.6.Гаалийн итгэмжлэл нь хүчингүй болсон аж ахуйн нэгж, байгууллага шийдвэр гарсан өдрөөс хойш 1 жилийн дараа итгэмжлэл авах хүсэлт гаргаж болно.

----ooOoo---

Гаалийн ерөнхий газрын даргын
2019 оны А.128 дугаар тушаалын
Хоёрдугаар хавсралт



БҮРДҮҮЛСЭН БИЧИГ БАРИМТЫН ЖАГСААЛТ

.....он.....сар.....өдөр

А	Хүсэлт гаргагчийн нэр:		Регистрийн дугаар:	Үндсэн харьяалал, хаяг	
Б	Тээвэрлэлт хийх замын маршрут:		Харьяалах гаалийн газар, хорооны нэр:		
В	Тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн хэрэгслийн тоо:		Улс хоорондын тээвэрлэлт гүйцэтгэх гэрээ:		
	<i>толгой</i>	<i>чиргүүл</i>	<i>дугаар</i>	<i>огноо</i>	<i>хугацаа</i>

№	Бүрдүүлэх бичиг баримтын жагсаалт	Баримтжуулалт		
		Дугаар	Огноо	Хуудасны тоо
1	Итгэмжлэл хүссэн өргөдөл			
2	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар			
3	Тээвэрлэгч байгууллагын танилцуулга			
4	Гаалийн газар, хорооны тодорхойлолт			
5	Тээврийн хэрэгслийн стандартын шаардлага хангасан талаарх дүгнэлт			
6	Автотээврийн хэрэгслийн жагсаалт			
7	Фото зураг, тээврийн хэрэгслийн гэрчилгээ			
8	Тээврийн хэрэгслийн байршлыг тогтоох систем /GPS, цахим ломбо/-ийн тухай танилцуулга			
9	Ачаа тээвэрлэх талаар өөр аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээ			
10	Татвар, хураамж төлж барагдуулах баталгаа			
11	Санхүүгийн тайлангийн хуулбар			
12	Даатгалын байгууллагын тодорхойлолт Ачаа тээвэрлэлтийн даатгал			
13	Татварын байгууллагын тодорхойлолт			
14	Бүрдүүлсэн бичиг баримтын цахим хуулбар			
НИЙТ ДҮН				

Г	Холбоо барих ажилтны нэр, утас		Email хаяг

ЗАХИРАЛ...../...../

Тамга, гарын үсэг,

овог нэр




Гаалийн ерөнхий газрын даргын
2019 оны А.12-дугаар тушаалын
Гуравдугаар хавсралт

.....ХХК-ИЙН АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ЖАГСААЛТ


Д/д	Автомашин ерөнхий мэдээлэл						Чиргүүлийн мэдээлэл				Тээврийн хэрэгслийг хариуцах жолоочийн мэдээлэл							
	Улсын дугаар	Марк	Модел	Тэнхлэгийн тоо	Арлын дугаар	Даац кг-р	Өөрийн жин /кг-р/	Өнгө	Үйлдвэрлэсэн огноо	Улсын дугаар	Арлын дугаар	Даац /кг-р/	Өөрийн жин /кг-р/	Үйлдвэрлэсэн огноо	Овог	Нэр	Регистрийн дугаар	Хаяг

ЗАХИРАЛ...../...../.....
 Тамга/...../.....
 овог нэр гарын үсэг,

Гаалийн ерөнхий газрын даргын
2019 оны А.123 дугаар тушаалын
Дөрөвдүгээр хавсралт



“ГИТ” ТАНИХ ТЭМДЭГИЙН ЗАГВАР



Ар тал:

ГИТ-ийн нэр:
ГИТ-ийн код:
ГИТ-ийн эрх олгосон тушаал:
ГИТ-ийн эрх дуусах огноо:
Тээврийн хэрэгслийн дугаар:
Марк, модель: